



МОНГОЛЫН
ИТГЭМЖЛЭЛИЙН
ТОГТОЛЦОО

MNAS P 707

БАТЛАВ.
ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН
ТӨВИЙН ДАРГА

.....С.НЯМ-ЭРДЭНЭ

**ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН БАЙГУУЛЛАГА (MNAS)-ЫН
ТАНИХ ТЭМДГИЙГ ОЛОН УЛСЫН ИТГЭМЖЛЭЛИЙН
ФОРУМЫН ОЛОН ТАЛТ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ
ХЭЛЭЛЦЭЭР (IAF/MCA), ОЛОН УЛСЫН ЛАБОРАТОРИ
ИТГЭМЖЛЭЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
БАЙГУУЛЛАГЫН ХАРИЛЦАН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ
ХЭЛЭЛЦЭЭР (ILAC/MRA)-ИЙН ТЭМДЭГТЭЙ ХОСЛУУЛАН
ХЭРЭГЛЭХ ЖУРАМ**

Боловсруулсан	Хянаж, өөрчлөлт оруулсан:
Чанарын менежер	Ахлах мэргэжилтэн
Д.Удвал	З.Мөнхбат

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай, 4-р хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар 15170, Монгол Улс
Утас: (976) 77073689

Цахим хуудас: www.mnas.gov.mn

Цахим шуудан: info@mnas.gov.mn

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.

АНХ ХЭВЛЭСЭН ОГНОО: 25.06.2024

ӨӨРЧЛӨЛТ NO: xxx
ӨӨРЧЛӨЛТИЙН ОГНОО:

АГУУЛГА

Sl.	Бүлэг	ХуудасNo.
1.0	Зорилго	3
2.0	Хамрах хүрээ	3
3.0	Эш татсан баримт бичиг	3
4.0	Нэр томъёо, тодорхойлолт	3
5.0	Үүрэг хариуцлага	3
6.0	Үйл ажиллагаа	4
	6.1 MNAS итгэмжлэлийн тэмдэг ба IAF MLA/ILAC MRA тэмдгийн загвар	4
	6.2 Бэлгэ тэмдэг/таних тэмдгийг хуулбарлах	4
	6.3 Итгэмжлэлийн тогтолцооны таних тэмдэг ба IAF MLA/ILAC MRA тэмдгийг ашиглах	4
	6.4 Агуулга, хэмжээ, хуулбар	4
	6.5 MNAS-ийн таних тэмдэг болон IAF MLA /ILAC MRA тэмдгийг ашиглах нөхцөл	5
	6.6 Үйл явц	6
	6.7. Зөвшөөрөл авах	6
	6.8 Нөхцөлийг зөрчих	7
	6.9 Түдгэлзүүлэх, дуусгавар болгох арга хэмжээ	7
7.0	Бүртгэлүүд	8
	ХАВСПАЛТ 1 Үндэсний итгэмжлэлийн тогтолцооны бэлгэ тэмдэг (MNAS)	10
	ХАВСПАЛТ 2 Үндэсний итгэмжлэлийн тогтолцооны таних тэмдэг (MNAS)-тэй ILAC MRA/ IAF MLA тэмдэгтэй хосолсон байдал	10
	Өөрчлөлтийн бүртгэл	11

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Дос No: MNAS P 707	Үндэсний итгэмжлэлийн байгууллага (MNAS)-ын таних тэмдгийг ILAC MRA/IAF MLA тэмдэгтэй хослуулан хэрэглэх журам.	
Хэвлэсэн огноо: 25.06.2024	Өөрчлөлтийн дугаар №:xxx	Page No: 2/11
	Өөрчлөлтийн огноо:	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

**ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ТАНИХ ТЭМДГИЙГ IAF (ОЛОН
УЛСЫН ИТГЭМЖЛЭЛИЙН ФОРУМ), ILAC (ОЛОН УЛСЫН ЛАБОРАТОРИ
ИТГЭМЖЛЭЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА) -ЫН ОЛОН ТАЛТ
ХАРИЛЦАН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТЭМДЭГТЭЙ ХОСЛУУЛАН
ХЭРЭГЛЭХ ЖУРАМ**

MNAS P 707

1.0 Зорилго

Ази номхон далайн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (APAC), Олон улсын итгэмжлэлийн форум (IAF), Олон улсын лабораторийн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (ILAC)-ын XXЗХ-ийн тэмдгийг үндэсний итгэмжлэлийн байгууллагын (MNAS)-ны таних тэмдэгтэй хослуулан хэрэглэх нөхцөлийг тодорхойлох, түүнд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулна.

2.0 Хамрах хүрээ

Энэхүү журам нь итгэмжлэлийн тэмдэг болон бусад итгэмжлэлийн мэдэгдлийг ашиглах, итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-ууд, тэдгээрийн үйлчлүүлэгчдэд хамаарна.

3.0 Эш татсан баримт бичиг

- MNAS P 707 Үндэсний итгэмжлэлийн байгууллагын таних тэмдгийг IAF MLA/ILAC MRA тэмдэгтэй хослуулан хэрэглэх журам
- ILAC P 8 Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагуудын итгэмжлэлийн тэмдгийг ашиглах болон итгэмжлэлийн статусын шаардлагад тавих нэмэлт шаардлага
- ILAC R 7 ILAC MRA таних тэмдгийг ашиглах дүрэм
- IAF ML 2 IAF MLA таних тэмдгийг ашиглах ерөнхий зарчим

4.0 Нэр томьёо, тодорхойлолт

4.1 Үндэсний итгэмжлэлийн байгууллага (MNAS)-ын таних тэмдэг-Итгэмжлэлийн байгууллагаас итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагад олгосон итгэмжлэлийн дугаар бүхий тэмдгийн хослол байна.

Энэхүү тэмдгийг ТҮБ-ууд итгэмжлэгдсэн гэдгээ илэрхийлэх зорилгоор ашиглана.

4.2 Үндэсний итгэмжлэлийн тогтолцоо (MNAS)-ны бэлгэ тэмдэг –Итгэмжлэлийн байгууллагын бэлгэ тэмдэг нь өөрийгөө олон нийтэд таниулах, мэдээлэх зорилгоор ашиглана.

MNAS бэлгэ тэмдэг нь Үндэсний итгэмжлэлийн байгууллагын өмч бөгөөд өөр ямар нэгэн байгууллага ашиглах эрхгүй. MNAS таних тэмдэг нь хуулиар хамгаалагдсан байна.

4.3 APAC, IAF, ILAC зэрэг бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудын Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр /IAF MLA/ILAC MRA/-т гарын үсэг зурсан итгэмжлэлийн байгууллага, итгэмжлэгдсэн ТҮБ-уудын ашиглах тэмдгийг заана.

5.0 Үүрэг хариуцлага

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Doc No: MNAS P 707	Үндэсний итгэмжлэлийн байгууллага (MNAS)-ын таних тэмдгийг ILAC MRA/IAF MLA тэмдэгтэй хослуулан хэрэглэх журам.	
Хэвлэсэн огноо: 25.06.2024	Өөрчлөлтийн дугаар №:xxx	Page No: 3/11
	Өөрчлөлтийн огноо:	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

Чанарын менежер- Журмыг бий болгох, хэрэгжүүлэх, өөрчлөх, хэрэгжилтэд хяналт тавих бүртгэл хөтлөх, хадгалах

Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага нь энэхүү журмыг дагаж мөрдөнө.

6 Үйл ажиллагаа

6.1 MNAS-ийн итгэмжлэлийн таних тэмдэг ба IAF MLA/ILAC MRA таних тэмдгийн загвар

6.1.1 Үндэсний итгэмжлэлийн байгууллага (MNAS)-ын таних тэмдэг нь MNAS-ын бэлгэ тэмдгийн дор бичигдсэн итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-д олгосон итгэмжлэлийн тусгай дугаар бүхий бэлгэ тэмдгийн хослол байна.

6.1.2 Үндэсний итгэмжлэлийн байгууллага /MNAS/-ын таних тэмдгийн загварыг А Хавсралт-д, итгэмжлэлийн тэмдэг болон IAF MLA/ILAC MRA хосолсон тэмдгийг Хавсралт 'В'-д өгсөн болно.

6.1.3 Баталгаажуулалтын байгууллага/баталгаа/нотолгооны байгууллагуудад зориулсан IAF MLA хосолсон тэмдэг (IAF ML2), сорилт, шалгалт тохируулга, техникийн хяналтын байгууллагууд ILAC MRA тэмдэг (ILAC R7)-ийн баримт бичгийн сүүлийн хувилбаруудад тайлбарласны дагуу тусгай шаардлагад үндэслэн ашиглахыг зөвшөөрнө.

6.1.4 Итгэмжлэгдсэн ТҮБ-ууд нь IAF MLA/ILAC MRA-ийн хосолсон тэмдгийг MNAS-тай байгуулсан тусгай гэрээний дагуу ашиглана.

6.2 Бэлгэ тэмдэг/таних тэмдгийг хуулбарлах

6.2.1 Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага нь итгэмжлэлийн дугааргүйгээр итгэмжлэлийн таних тэмдгийг ашиглахгүй.

6.2.2 Итгэмжлэгдсэн ТҮБ нь итгэмжлэлийн таних тэмдгийг IAF MLA эсвэл ILAC MRA тэмдэгтэй хамтад нь В хавсралтад үзүүлсэн загварын дагуу итгэмжлэгдсэн үйл ажиллагааны хүрээнд гэрчилгээ, тайланд ашиглаж болно. Итгэмжлэлийн таних тэмдэг болон IAF MLA/ ILAC MRA тэмдгийг нэрийн хуудсан дээр хэвлэж болохгүй.

6.3 Итгэмжлэлийн таних тэмдэг ба IAF MLA/ILAC MRA тэмдгийг ашиглах

6.3.1 Үндэсний итгэмжлэлийн байгууллагаар итгэмжлэгдсэн ТҮБ-ууд болон тэдгээрийн үйлчлүүлэгч байгууллагууд нь итгэмжлэлийн таних тэмдэг, IAF MLA/ILAC MRA хосолсон тэмдгийг ашиглах нь зөвшөөрөгдсөн авсан тохиолдолд ашиглана.

6.3.2 Итгэмжлэгдсэн ТҮБ нь итгэмжлэлийн таних тэмдгийг өөрөө эсвэл итгэмжлэгдсэн ТҮБ-ын үйлчлүүлэгч байгууллагууд ашиглах нь дор дурдсан нөхцөлтэй нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд зохих арга хэмжээ авна.

6.3.3 Үндэсний итгэмжлэлийн байгууллагаас итгэмжлэгдсэн ТҮБ-уудын үйлчлүүлэгч байгууллагууд IAF MLA тэмдгийг ашиглахгүй.

6.3.4 ILAC MRA тэмдгийг ТҮБ-ын үйлчлүүлэгчид ашиглахгүй.

6.4 Агуулга, хэмжээ, хуулбар

- а) Итгэмжлэлийн байгууллагын бэлгэ тэмдэг нь А хавсралтад үзүүлсэн загвартай байна. Бэлгэ тэмдгийн дэвсгэр өнгө нь хөх (С 100%, М 060%, Y 000%, К 000%), соёмбоны өнгө нь шар (С 000%, М 015%, Y 100%, К 000%) болон MNAS, Accreditation system гэсэн үгнүүд цагаан

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Doc No: MNAS P 707	Үндэсний итгэмжлэлийн байгууллага (MNAS)-ын таних тэмдгийг ILAC MRA/IAF MLA тэмдэгтэй хослуулан хэрэглэх журам.	
Хэвлэсэн огноо: 25.06.2024	Өөрчлөлтийн дугаар №:xxx	Page No: 4/11
	Өөрчлөлтийн огноо:	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

өнгөтэй байна. Бэлгэ тэмдгийг загварын дагуу томруулах буюу багасган хэрэглэж болох ба 2:1.5-ийн харьцаатай байна.

- b) Итгэмжлэлийн байгууллагаас итгэмжлэгдсэн ТҮБ-д олгогдох таних тэмдэг нь итгэмжлэлийн бэлгэ тэмдэг, бүртгэлийн дугаар, холбогдох стандартын тэмдэглэгээнээс бүрдэнэ. Таних тэмдгийг В хавсралтад заасан загварын дагуу томруулах буюу багасгаж хэрэглэж болох ба 2.4:1.5 харьцаатай байна.
- c) Итгэмжлэгдсэн ТҮБ-ууд нь В хавсралтад заасан MNAS-ийн бэлгэ тэмдгийн дор итгэмжлэлийн дугаар бүхий тэмдгийг хуулбарлаж хэрэглэнэ.
- d) MNAS итгэмжлэлийн тэмдгийг итгэмжлэгдсэн ТҮБ-ын тэмдэгнээс үйлчлүүлэгч байгууллага тусад нь хуулбарлаж болохгүй.
- e) IAF MLA / ILAC MRA хосолсон тэмдгийг MNAS-тай байгуулсан гэрээний үндсэн дээр IAF MLA таних тэмдэг (IAF ML 2) болон ILAC MRA таних тэмдгийг (ILAC R7) хамгийн сүүлд батлагдсан баримт бичгийн дагуу хуулбарлаж хэрэглэнэ.

6.5 MNAS-ийн таних тэмдэг болон IAF MLA /ILAC MRA тэмдгийг ашиглах нөхцөл

6.5.1 Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага нь итгэмжлэлийн тэмдэг болон IAF MLA/ILAC MRA тэмдгийг зөвхөн MNAS-аас олгосон итгэмжлэлийн хүрээ, ТҮБ-ын оффисын байршилд ашиглах боломжтой. Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага нь итгэмжлэлийн талаар төөрөгдүүлсэн эсвэл зөвшөөрөлгүй ямар нэгэн мэдэгдэл хийх ёсгүй.

- a) Итгэмжлэлийн тэмдэг эсвэл IAF MLA/ILAC MRA тэмдэг итгэмжлэгдсэн ТҮБ-ын статусыг зааж, шаардлагатай тохиолдолд олгосон итгэмжлэлийн гэрчилгээг ТҮБ-ын тэмдэгтэй хамт хэрэглэнэ.
- b) Итгэмжлэлийн таних тэмдэг эсвэл IAF MLA/ILAC MRA таних тэмдгийг ТҮБ түүний үйлчлүүлэгч байгууллагын итгэмжлэгдсэн статусын талаар хэрэглэгчдийг төөрөгдүүлэх байдлаар ашиглах ёсгүй.
- c) Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын хувьд баталгаажуулалтын байгууллага, итгэмжлэлийн байгууллагын бэлгэ тэмдгийг бүтээгдэхүүний сав баглаа боодол, шошго, сурталчилгааны материал, мэдэгдэл гэх мэт зүйлд ашиглахыг хориглодог бөгөөд энэ нь баталгаажуулалтын байгууллага эсвэл итгэмжлэлийн байгууллага нь аливаа бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээг төөрөгдүүлсэн байдлаар баталгаажуулсан эсвэл зөвшөөрсөн болохыг харуулна. Бүтээгдэхүүний баталгаажуулалтын байгууллага нь бүтээгдэхүүний тохирлын тэмдэг, удирдлагын тогтолцоонд ашигладаг аливаа тэмдэг /лого/ нь ялгаатай байна. Бүтээгдэхүүн дээр MNAS-ийн таних тэмдэг ашиглахыг хориглоно.
- d) Итгэмжлэлийн тэмдэг эсвэл IAF MLA/ ILAC MRA тэмдгийг том хэмжээний сурталчилгааны материалаас бусад тохиолдолд тээврийн хэрэгсэлд байршуулж харуулахыг хориглоно.
- e) Итгэмжлэлийн тэмдэг эсвэл IAF MLA/ ILAC MRA тэмдгийг барилга байгууламж, туг, далбаа дээр байрлуулж болохгүй.
- f) Итгэмжлэлийн таних тэмдэг эсвэл IAF MLA / ILAC MRA тэмдэг бүхий итгэмжлэгдсэн ТҮБ-ын үнийн санал, гэрээнд MNAS-аар итгэмжлэгдээгүй үйл ажиллагааны тодорхой хэсгийг зааж өгөх ёстой.
- g) Итгэмжлэлийн тэмдэг эсвэл IAF MLA/ ILAC MRA тэмдгийг нэрийн хуудсанд ашиглахыг хориглоно.
- h) Итгэмжлэгдсэн ТҮБ нь итгэмжлэлээ түдгэлзүүлсэн эсвэл цуцалсны дараа MNAS-ийн таних тэмдэг эсвэл IAF MLA/ILAC MRA тэмдэг болон итгэмжлэгдсэн статустай холбоотой аливаа сурталчилгааны материалыг ашиглахыг зогсооно.
- i) Итгэмжлэгдсэн ТҮБ-ын бүтээгдэхүүн, үйл явц, тогтолцоо эсвэл этгээдийг итгэмжлэлийн

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Doc No: MNAS P 707	Үндэсний итгэмжлэлийн байгууллага (MNAS)-ын таних тэмдгийг ILAC MRA/IAF MLA тэмдэгтэй хослуулан хэрэглэх журам.	
Хэвлэсэн огноо: 25.06.2024	Өөрчлөлтийн дугаар №:xxx	Page No: 5/11
	Өөрчлөлтийн огноо:	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

байгууллагаас зөвшөөрсөн гэж үзэх хүртэл өөрийн итгэмжлэлийн баримт материалыг ашиглахыг зөвшөөрөхгүй.

6.6 Үйл явц

6.6.1 Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага нь итгэмжлэлийн хосолсон тэмдэг болон ILAC MRA/IAF MLA тэмдгийг ашиглахыг хүссэн дэд лицензийн гэрээнд гарын үсэг зурна.

- MNAS P 707 F 03 Үндэсний итгэмжлэлийн тогтолцоо (MNAS)-ны таних тэмдэг болон IAF MLA тэмдгийг ашиглах дэд лицензийн гэрээ;
- MNAS P 707 F 04 Үндэсний итгэмжлэлийн тогтолцоо (MNAS)-ны таних тэмдэг болон ILAC MRA тэмдгийн дэд лицензийн гэрээ.

6.6.2 Итгэмжлэлийн хосолсон тэмдэг болон ILAC MRA/IAF MLA тэмдгийг ашиглахдаа итгэмжлэгдсэн байгууллагууд дараахь баримт бичгийг дагаж мөрдөнө.

- Энэхүү баримт бичиг MNAS P707 журам холбогдох дэд лиценз (MNAS P707 F03, MNAS P707 F04);
- ILAC P 8 Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагуудын итгэмжлэлийн тэмдгийг ашиглах болон итгэмжлэлийн статусын тухай мэдэгдэлд тавих нэмэлт шаардлага;
- IAF ML 2 IAF MLA тэмдэг ашиглах ерөнхий зарчим;
- ILAC R 7 ILAC MRA тэмдгийг ашиглах дүрэм.

6.7 Зөвшөөрөл авах

6.7.1 Итгэмжлэлийн хосолсон тэмдэг болон ILAC MRA/IAF MLA тэмдгийг ашиглах зөвшөөрөл авах үйл ажиллагааг дараах байдлаар тодорхойлно.

6.7.2 Итгэмжлэлийн хосолсон тэмдэг болон ILAC MRA/IAF MLA тэмдгийг ашиглах хүсэлт гаргасан ТҮБ нь 6.2 дахь заалтыг дагаж мөрдөнө.

6.7.3 Итгэмжлэгдсэн ТҮБ нь итгэмжлэлийн тэмдэг болон ILAC MRA/IAF MLA тэмдгийг ашиглахын тулд Үндэсний итгэмжлэлийн байгууллагад өргөдлийг MNAS P707 F01 Үндэсний итгэмжлэлийн тогтолцооны таних тэмдгийг IAF (олон улсын итгэмжлэлийн форум)-ын олон талт хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийн тэмдэгтэй хослуулан хэрэглэх хүсэлт гаргах өргөдөл, MNAS P707 F02 Үндэсний итгэмжлэлийн тогтолцооны таних тэмдгийг ILAC (International Laboratory Accreditation Cooperation) MRA (Mutual Recognition Arrangement) тэмдэгтэй хослуулан хэрэглэх өргөдлийн маягтын дагуу гаргана.

6.7.4 Чанарын менежер өргөдлийг хүлээн авч, тохирлын үнэлгээний байгууллага руу MNAS P707 F03 Олон улсын итгэмжлэлийн форум (IAF)-ын таних тэмдгийг хамтран ашиглах гэрээ, MNAS P707 F04 Олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (ILAC)-ын таних тэмдгийг хамтран ашиглах гэрээний маягтыг илгээнэ.

6.7.5 ТҮБ нь MNAS P707 F03/ MNAS P707 F04 гэрээнд гарын үсэг зурснаар итгэмжлэлийн хосолсон тэмдэг болон ILAC MRA/IAF MLA тэмдгийг ашиглах дүрмийг зөвшөөрч, холбогдох гарын үсэг бүхий маягтыг Чанарын менежерт ирүүлднэ.

6.7.6 Чанарын менежер нь итгэмжлэлийн хосолсон тэмдэг болон ILAC MRA/IAF MLA тэмдгийг ТҮБ-д илгээнэ.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Doc No: MNAS P 707	Үндэсний итгэмжлэлийн байгууллага (MNAS)-ын таних тэмдгийг ILAC MRA/IAF MLA тэмдэгтэй хослуулан хэрэглэх журам.	
Хэвлэсэн огноо: 25.06.2024	Өөрчлөлтийн дугаар №:xxx	Page No: 6/11
	Өөрчлөлтийн огноо:	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

6.7.7 ТҮБ нь итгэмжлэлийн тэмдэг болон ILAC MRA/IAF MLA тэмдгийг ашиглах жишээг тайлан/хэвлэмэл хуудас дээр бэлтгэж, Чанарын менежерт цахим шуудангаар илгээнэ.

6.7.8 Чанарын менежер нь итгэмжлэлийн хосолсон тэмдэг болон ILAC MRA/IAF MLA тэмдгийн хэрэглээ MNAS P707 журамтай нийцэж байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв журмыг дагаж мөрдөөгүй бол Чанарын менежер нь гаргасан алдааны талаар ТҮБ-д мэдэгдэх бөгөөд ТҮБ нь зассан зөв хувилбарыг ирүүлнэ.

6.7.9 Чанарын менежер нь итгэмжлэлийн хосолсон тэмдэг болон ILAC MRA/IAF MLA тэмдгийг ашиглах тухай зөвшөөрсөн албан бичгийг ТҮБ-д илгээнэ.

6.7.10 Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага нь 6.7.9-д заасан зөвшөөрлийн албан бичгийг итгэмжлэлийн хосолсон тэмдэг болон ILAC MRA/IAF MLA тэмдгийг ашиглах нотлох баримт болгоно.

6.7.11 Итгэмжлэлийн хосолсон тэмдэг болон ILAC MRA/IAF MLA тэмдгийн ашиглалтын нөхцөлийг хангаж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд үнэлгээ бүр дээр хянаж шалгана.

6.7.12 Чанарын менежер нь Итгэмжлэлийн хосолсон тэмдэг болон ILAC MRA/IAF MLA тэмдгийг хослуулан ашиглаж буй байгууллагын гэрээний бүртгэлийг MNAS P707 F05 маягтын дагуу хөтөлж, хяналт тавьж ажиллана.

6.8 Нөхцөлийг зөрчих

6.8.1 Итгэмжлэлийн тэмдэг эсвэл IAF MLA/ILAC MRA тэмдгийг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага эсвэл түүний үйлчлүүлэгч байгууллага заасан нөхцөлийг зөрчсөн тохиолдолд холбогдох арга хэмжээг авч, шаардлагатай бол залруулах арга хэмжээ авах талаар харилцагч байгууллагад мэдээнэ. Үйлчлүүлэгч байгууллага удаа дараа зөрчил гаргасан тохиолдолд ТҮБ нь тохирлын үнэлгээний гэрчилгээг буцаан авч болно. Итгэмжлэгдсэн ТҮБ нь итгэмжлэлийн тэмдэг эсвэл IAF MLA/ILAC MRA тэмдгийг зүй бусаар ашигласан тохиолдолд зохих арга хэмжээ авч чадаагүй тохиолдолд Үндэсний итгэмжлэлийн байгууллага нь ТҮБ-ын итгэмжлэлийг түдгэлзүүлж/хүчингүй болгож болно.

6.8.2 Итгэмжлэгдсэн ТҮБ нь тогтоосон нөхцөл шаардлагыг хэрэгжүүлээгүй тохиолдолд Үндэсний итгэмжлэлийн байгууллага зохих арга хэмжээ авч, залруулах арга хэмжээний талаар холбогдох ТҮБ-д зөвлөмж хүргүүлнэ.

Эдгээр нөхцөлүүд нь итгэмжлэлийн статусын талаар буруу эсвэл зөвшөөрөлгүй мэдэгдэл гаргах, MNAS-ын таних тэмдгийг төөрөгдүүлсэн буюу зөвшөөрөлгүй ашиглах зэргийг багтаах ба үүгээр хязгаарлагдахгүй.

Тохиромжтой арга хэмжээ нь зөрчлийн ноцтой байдлаас хамааран залруулах арга хэмжээ авах хүсэлт гаргах, итгэмжлэлийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах, зөрчлийг нийтлэх, шаардлагатай бол хуулийн арга хэмжээ авах зэрэг үйлдлүүд байж болно.

6.9 Түдгэлзүүлэх, дуусгавар болгох арга хэмжээ

6.9.1 MNAS итгэмжлэлийг түдгэлзүүлсний дараа итгэмжлэгдсэн ТҮБ нь итгэмжлэлийн тэмдэг эсвэл IAF MLA/ILAC MRA тэмдэг бүхий баримт бичиг, гэрчилгээ болон бусад сурталчилгааны материалд ашиглахыг нэн даруй зогсооно. Үндэсний итгэмжлэлийн байгууллага нь итгэмжлэлийг түдгэлзүүлж, цуцалсны дараа дахин ашиглах боломжийг өгч болно.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Doc No: MNAS P 707	Үндэсний итгэмжлэлийн байгууллага (MNAS)-ын таних тэмдгийг ILAC MRA/IAF MLA тэмдэгтэй хослуулан хэрэглэх журам.	
Хэвлэсэн огноо: 25.06.2024	Өөрчлөлтийн дугаар №:xxx	Page No: 7/11
	Өөрчлөлтийн огноо:	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

6.9.2 Итгэмжлэлийг сунгаагүй/цуцалсны улмаас итгэмжлэгдсэн ТҮБ нь MNAS таних тэмдэг эсвэл IAF MLA / ILAC MRA тэмдэг бүхий баримт бичиг, гэрчилгээ болон бусад сурталчилгааны материалыг ашиглахаа нэн даруй зогсооно.

7.0 Records

- MNAS P707 F01 Үндэсний итгэмжлэлийн байгууллага (MNAS)-ын таних тэмдгийг IAF MLA тэмдэгтэй хослуулан хэрэглэх өргөдлийн маягт
- MNAS P707 F02 Үндэсний итгэмжлэлийн байгууллага (MNAS)-ын таних тэмдгийг ILAC MRA тэмдэгтэй хослуулан хэрэглэх өргөдлийн маягт
- MNAS P707 F03 Үндэсний итгэмжлэлийн байгууллага (MNAS)-ын таних тэмдгийг IAF MLA тэмдэгтэй хослуулан хэрэглүүлэх дэд лицензийн гэрээний маягт
- MNAS P707 F04 Үндэсний итгэмжлэлийн байгууллага (MNAS)-ын таних тэмдгийг ILAC MRA тэмдэгтэй хослуулан хэрэглэх гэрээний маягт
- MNAS P707 F05 Олон улсын итгэмжлэлийн форумын Олон талт харилцан зөвшөөрөх хэлэлцээр (IAF MLA), Олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (ILAC MRA) тэмдгийг хамтран ашиглах гэрээний бүртгэл

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Дос No: MNAS P 707	Үндэсний итгэмжлэлийн байгууллага (MNAS)-ын таних тэмдгийг ILAC MRA/IAF MLA тэмдэгтэй хослуулан хэрэглэх журам.	
Хэвлэсэн огноо: 25.06.2024	Өөрчлөлтийн дугаар №:xxx	Page No: 8/11
	Өөрчлөлтийн огноо:	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

ХАВСРАЛТ 1

Итгэмжлэлийн бэлгэ тэмдэг (лого)-ийн загвар



ХАВСРАЛТ 2

Үндэсний итгэмжлэлийн тогтолцооны таних тэмдэг (MNAS)
ILAC MRA/ IAF MLA тэмдэгтэй хосолсон байдал

Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага

ILAC MRA/MNAS хосолсон тэмдэг



IAF MLA/MNAS хосолсон тэмдэг



xxx нь итгэмжлэлийн байгууллагаас тохирлын үнэлгээний байгууллагад
олгосон итгэмжлэлийн дугаар

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Дос No: MNAS P 707	Үндэсний итгэмжлэлийн байгууллага (MNAS)-ын таних тэмдгийг ILAC MRA/IAF MLA тэмдэгтэй хослуулан хэрэглэх журам.	
Хэвлэсэн огноо: 25.06.2024	Өөрчлөлтийн дугаар №:xxx	Page No: 9/11
	Өөрчлөлтийн огноо:	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

**Олон улсын итгэмжлэлийн форумын Олон талт харилцан зөвшөөрөх хэлэлцээр (IAF MLA),
Олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага Харилцан хүлээн
зөвшөөрөх хэлэлцээр (ILAC MRA) тэмдгийг хамтран ашиглах гэрээний бүртгэл**

№	ТҮБ-ын нэр	Гэрээ байгуулсан огноо	Гэрээний дугаар	Гэрээ хүчинтэй эсэх

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ			
Дос No: MNAS P 707	Үндэсний итгэмжлэлийн байгууллага (MNAS)-ын таних тэмдгийг ILAC MRA/IAF MLA тэмдэгтэй хослуулан хэрэглэх журам.		
Хэвлэсэн огноо: 25.06.2024	Өөрчлөлтийн дугаар №:xxx		Page No: 10/11
	Өөрчлөлтийн огноо:		
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.			

Өөрчлөлтийн бүртгэл

№	Өөрчлөлтийн дугаар	Хуудасны дугаар	Өөрчлөлт оруулсан шалтгаан
1			

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Дос No: MNAS P 707	Үндэсний итгэмжлэлийн байгууллага (MNAS)-ын таних тэмдгийг ИЛАС MRA/IAF MLA тэмдэгтэй хослуулан хэрэглэх журам.	
Хэвлэсэн огноо: 25.06.2024	Өөрчлөлтийн дугаар №:xxx	Page No: 11/11
	Өөрчлөлтийн огноо:	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		